



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/А93

Булган сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 25/05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/705 дугаар "Соёлын биет бус өвийг уламжилж, сурталчлан түгээн дэлгэрүүлсэн өв уламжлагчид урамшуулал олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын биет бус өвийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан уран дархан Содовын Чулуунд журмын дагуу урамшуулал олгосугай.

2. Урамшуулалд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

